

“Авилгатай тэмцэхэд Засгийн газрын байгууллагуудын хамтын ажиллагааг хангах нь” /Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр/

Монгол Улсын Ерөнхийлөгч өө, Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ, Хүндэт зочдоо, Хатагтай, ноёдоо

Эрхэм нөхдөө

Үндэсний Бага Хуралд хүрэлцэн ирсэн Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн ардчилсан тогтолцоо, түүний хэвийн, шударга ажиллах механизмыг гацаадаг, хөгжлийн тэнцвэрийг алдагдуулдаг, , нийгмийн тэгш бус байдлыг дэвэргэдэг, иргэдийг үгүйрэл, цөхрөл, үл итгэлцэл, хагарал хонзогнолын үзлээр хордуулдаг, бүхэлдээ үндэсний өрсөлдөх болон хөгжих чадварыг сульдаадаг, улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын дархлааг сулруулдаг гээд муу үр дагавар бүхнийг дагуулдаг “авилга”-ын талаар өнөөдөр дахин давтан хэлэлцэх, түүнчлэн түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлыг хамтдаа ярилцахаар зохион байгуулж буй энэхүү арга хэмжээнд Та бид өндөр ач холбогдол өгч байна.

Нийгмийн ийм урхаг, хорлонтой үзэгдлийн эсрэг олон нийтийн анхаарлыг хандуулж, нийтээрээ тэмцэх, түүнийг үл тэвчих үзэл бодлыг нийгэмд төлөвшүүлэхэд энэхүү Бага хурлын ач холбогдол орших болов уу гэж бодож байна.

Авилгатай тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд бид багагүй үр дүнд хүрсэн гэж хэлж болохоор байгаа билээ.

Тухайлбал, “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан, Авилгын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Конвенцид нэгдсэн, мөрдөн байцаах болон гүйцэтгэх ажил явуулах, олон нийтийг соён гэгээрүүлэх, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй болгох зэрэг НҮБ-ын Конвенцийн үзэл санаа, гол заалтуудыг өөртөө агуулсан Авилгатай тэмцэх тухай хуулийг шинэчлэн баталсан, бүр тусгайлсан байгууллагыг ч байгуулж чадсан гээд өөрсдийн ололтыг тоочиж болох байна.

Гэвч эдгээр асуудлыг миний өмнө үг хэлж, илтгэл тавьсан хүмүүс нилээд тодорхой өгүүлсэн учраас энэ чиглэлээр олныг давхардуулан

хөврүүлэлгүй **авилга**, бүр бодитойгоор оршиж байгаа энэ үзэгдлийн талаар тодорхой судалгаанд тэр тусмаа хөндлөнгийн зарим судалгаанд тулгуурлан ярихыг хүсч байна.

Судалгаа гэж ярих болсны учир нь бид хууль тогтоомж, конвенц, хөтөлбөр гэхийн сацуу Монголын нийгэмд бүр бодитойгоор нүүрлээд байгаа авилга, нийгмийн энэ гаж үзэгдлийн талаарх олон нийтийн үнэлэмж, түүнтэй тэмцэх, таслан зогсоох, эхний шатанд бууруулахад чиглэсэн ямар арга байж болох зэрэг олон чухал асуудлыг хөндсөн судалгаа хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй Засгийн газрын байгууллагуудад нэн чухал мэдээлэл болдогийг тэмдэглэж байна.

Монгол Улс дахь авилгын чиг хандлагыг тодорхойлох 3 удаагийн судалгааг Азийн сангаас “Сант марал” сантай хамтран 2006 оны 3, 9 дүгээр сар, 2007 оны 3 дугаар сард тус тус олон нийтийн дунд явуулсан байна.

Санамсаргүй түүврийн аргыг хэрэглэсэн энэхүү судалгаанд Улаанбаатар хот, зарим аймгийн 600-1030 иргэд хамрагдсан бөгөөд судалгааны асуулгыг жил бүр Авилгын түвшин тогтоох индексийг тодорхойлдог олон улсын Төрийн бус байгууллага болох “Transparency International”-ын нэгдсэн хэмжүүр буюу Global Corruption Barometer /GCB/-ийг үндэслэн явуулсан байна. Энэ нь авилгын тухай иргэдийн ойлголт, авилгад оролцсон байдал зэргийг хэмждэг хэмжүүр болдог.

Судалгаанд оролцогчдын 90% нь авилгыг Монгол Улсад газар авсан, түгээмэл үзэгдэл хэвээр байгаа гээд Монголд нүүрлээд байгаа тулгамдсан асуудлын хоёр дахь нь гэж тодорхойлсон байна. Нэгдүгээрт ажилгүйдэл ордог бол ядуурал нь авилгыг удаалж байна.

Авилгатай тэмцэх тухай шинэ хууль батлагдсанаар байдал сайжирна гэж үзэж байгаа иргэдийн тоо 2006 оны 9 дүгээр сард 35,4 хувь байсан бол энэ оны 3 дугаар сарын байдлаар 40 хувь болтлоо нэмэгдсэн нь бага боловч ахисан үзүүлэлт юм.

Сонгож авсан 23 салбарын авилгад автсан байдлаар нь эрэмбэлсэн зэрэглэлд бараг өөрчлөлт ороогүй байна. Нийтдээ 3 удаагийн судалгааны дүнгээр **газрын алба, гааль, уул уурхайн салбар** эхний 3 байранд ээлжлэн орж байна. Эдгээрийн араас татвар, бүртгэл, зөвшөөрөл олгож буй төрийн байгууллагууд, шүүх, цагдаа, прокурор, улс төрийн нам гээд бүр хүн ардын эрүүл мэндийн манаанд зогсож байх үүрэгтэй эрүүл мэндийн салбар авилгад хамгийн их өртөж байгаа топ 10 байгууллагын тоонд багтсан байна.

Олон нийтийн дунд 3 удаа явуулсан судалгаагаар авилгатай хийх тэмцлийг Авилгатай тэмцэх тусгайлсан байгууллага тэргүүлэх ёстой гэж үзэж байсан ба уг байгууллагыг дэмжигсдийн тоо 51.5% хүртэл өссөн байна.

Харин Засгийн газрын тэргүүлэх үүрэг эрс буурч 27%-д хүрсэн байна.

Эндээс хийж болох нэг дүгнэлт бол олон нийтийн итгэх итгэлийг Авилгатай тэмцэх газар дааж, шийдэмгий, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь зүйтэй байна.

Энэ нь олон нийтийн итгэлийг цаашид улам бэхжүүлэхэд нааштай алхам болох юм.

Судалгааны хамгийн сүүлийн дүнгээс харвал авилгыг нийгэмд хүлээн зөвшөөрөх уур амьсгал бүрдсэн, Засгийн газар болон улс төрийн хүрээнийхэн авилгатай тэмцэх эрмэлзэл бага, түүгээр ч барахгүй тэдэнд авилга ашигтай гэсэн судалгаанд оролцогчдын сэтгэгдэл хүчтэй байна.

Харин Авилгатай тэмцэх газраас олон нийт ихийг хүлээж, найдвар тавьж байгааг дахин тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Дээрх судалгааны дүнг товчхон боловч дурдах болсон шалтгаан нь Засгийн газрын байгууллагуудын зүгээс нэгэнт олон нийтэд байнга мэдээлэгдэж ирсэн, хийснээ дахин давтан ярих, тайлагнахыг чухалчилгүй харин бодит байдалд дүгнэлт хийж, авилгыг бууруулах чиглэлээр хэрхэн үр дүнтэй ажиллах, цаашид юу хийх, нийгэмд үүсэн нөхцөл байдал, авилгыг хүлээн зөвшөөрч, түүнд бүр гөлгөр хандах болсон нийгмийн сэтгэл зүйг алхам алхамаар өөрчлөх чиглэлээр хэрхэн ажиллах талаар ярих нь илүү өгөөжтэй байх болов уу гэж үзлээ.

Гэхдээ энэ бүхний эхэнд Засгийн газрын байгууллагуудаас авилгатай тэмцэх чиглэлээр ямар ажлыг хийж гүйцэтгэв, зохион байгуулав гэдгийг товчхон боловч мэдээлье.

Засгийн газрын байгууллагуудын тухайд авилгатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаандаа мөрдөж буй бодлогын шинжтэй баримт бичиг, үйл ажиллагааны болоод хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу өөрсдөөс хамаарах бүхнийг хийж байгаа гэдгийг ч дурдах нь зүйтэй болов уу.

Хуулийн хүрээнд яривал Засгийн газрын байгууллагууд нь Улсын Их Хурлаас гарах шийдвэрийг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохион байгуулах үүрэгтэй байгууллага байдаг.

Энэхүү үүргийг Засгийн газрын байгууллагуудад алба хашиж буй төрийн ажилтнууд биелүүлдэг, хэрэгжүүлдэг.

Төрийн үйлчилгээний хүрээнд авилгыг байнга нөхцөлдүүлж байдаг элдэв шат дамжлага, хүнд суртал, хөшүүн хойрго байдал, ажилтнуудын хайхрамжгүй цэвдэг харилцаанд иргэдийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байгаа байдлыг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээг Засгийн газрын байгууллагууд хэрэгжүүлж байна. Үүнд:

- **Мэдээллийг нээлттэй байлгах, түүний хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр**

Олон нийтийг мэдээллээр тогтмол, шуурхай хангах, түүний дотор хууль зүйн мэдээллээр хангах, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ”-г бий болгож, байгууллага, иргэдийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актын бүх төрлөөр цогц мэдээлэл авах боломжийг бүрдүүллээ.

Өөрөөр хэлбэл иргэд зөвхөн өөрт шаардлагатай хууль төдийгүй Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Олон улсын гэрээ, Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбар гээд эрх зүйн актаар үйлчлүүлэх боломжтой боллоо.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны хооронд 2002 оны 1 дүгээр сард байгуулсан Хөгжлийн зээлийн гэрээг хэрэгжүүлэх, шүүх, эрх зүйн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, хууль зүйн салбарт мэдээллийн технологийг нэвтрүүлэх зорилгоор хийгдсэн дээрх ажил 2006 оноос хэрэгжиж эхэлсэн юм.

Иргэд хууль тогтоомжийн талаарх хүссэн мэдээллээ интернетын www.legalinfo.mn хаягаар авч байна.

Энэхүү мэдээллийн санг сүлжээнд холбогдсон Засгийн газрын болоод хууль тогтоох, шүүх эрх мэдэл, Үндсэн хуулийн байгууллагууд гээд 30 гаруй байгууллага байнга баяжуулах, мэдээллийн найдвартай байдлыг хангах, түгээх үүрэг хүлээж байгаа юм.

Цаашид санхүүгийн болоод техникийн тааламжтай нөхцөл бүрдэхийн хирээр илүү олон байгууллагыг энэхүү сүлжээнд холбох, санд орох мэдээллийг нэмэгдүүлэх, түүнийг олон нийтэд түгээхэд анхаарч ажиллахыг эрмэлзэж байна.

Үүний зэрэгцээ нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээс санаачилж, ихээхэн хүчин чармайлт гарган боловсруулсан Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж эхэлсэн бөгөөд энэхүү хууль Үндсэн хуульд заасан иргэдээс мэдээлэл олж авах эрхээ эдлэхэд ихээхэн тустай эрх зүйн акт болох юм.

Иргэд маань мэдээлэлтэй байна гэдэг авилгаас урьдчилан сэргийлэх чухал нөхцөл бүрдэнэ гэдэгтэй та бүхэн санал нийлнэ гэдэгт итгэж байна.

- **Тусгай зөвшөөрлийг цөөлөх чиглэлээр**

Авилгатай тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн аж ахуйн аливаа үйл ажиллагааг Засгийн газрын байгууллагуудын тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлүүлэхээр зохицуулсан хууль тогтоомжийг дахин эргэн харах, тусгайлан зөвшөөрөл олгох шаардлагагүй зарим үйл ажиллагааг эрхлэх боломжийг иргэд, байгууллагад үлдээх өөрөөр хэлбэл энэ төрлийн зохицуулалтыг хялбаршуулах, цөөлөх, хүчингүй болгох зэрэг асуудлыг багцаар нь судалж байна.

Судалгааны урьдчилсан дүнгээр тусгай зөвшөөрлийн асуудлыг зохицуулж буй **Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай** хуулиас гадна одоо мөрдөгдөж буй 130 гаруй хуулинд “зөвшөөрөл”, “тусгай зөвшөөрөл”, “гэрчилгээ”, “лиценз” гэсэн үгээр томъёологдсон заалт байна.

Энэ бүхний ард ямар нэг хэмжээгээр зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх ёстой гэсэн шууд утга байна л гэсэн үг.

- **Засгийн газрын байгууллагын акт буюу Яамдын сайд, агентлагийн удирдлагын шийдвэрийг хууль нийцүүлэх, стандартчлах**

Авилгатай тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зөвхөн хуулиар хязгаарлалгүй, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Яамд, агентлагийн удирдлагаас дангаараа болон хамтран баталсан шийдвэрүүдийг нийтэд нь дахин хянах, бүртгэх, нэгдсэн санд байрлуулах, түүнээс мэдээлэл түгээх ажлыг эрчимтэй зохион байгуулж байна.

2006 оны 1 дүгээр сараас Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар санхүүжүүлж байгаа “Захиргааны шийдвэрийг стандартчлах төсөл”-ийн хүрээнд хийгдэж буй дээрх ажлын явцад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа, тодорхой харилцааг давхардуулан зохицуулсан, зохицуулах шаардлагатай харилцааг хийдэлтэй үлдээсэн, эсхүл иргэд, байгууллагаас үйл ажиллагаа явуулахад чөдөр тушаа болж байгаа шийдвэрүүдийг засаж, залруулах, хүчингүй болгох гээд бүхий л ажлыг Засгийн газрын байгууллагуудаас хамтдаа гүйцэтгэхээр төлөвлөж, зохион байгуулж байна.

Тухайлбал, 2006 оны 2-11 сарын хооронд нийт 13 яам, 28 агентлагийн 2684 тушаал буюу 37 100 /гучин долоон мянга нэг зуун/ хуудас материалыг цуглуулж, бүртгэх, мэдээллийн нэгдсэн санд оруулах, салбар, төрөл, хамрах хүрээгээр системчлэх ажлыг гүйцэтгэж байна.

“Захиргааны шийдвэрийг стандартчлах төсөл”-ийг хэрэгжүүлэх хүрээнд тавьж буй зорилт бол хууль дагаж батлагддаг буюу Яамд, агентлагын удирдлагын тушаалаар батлагддаг дүрэм, журмыг боловсруулах, батлах, бүртгүүлэх, олон нийтэд хүргэх гээд үе шатны бүх ажлыг хуулийн чанд зохицуулалттай болгоход чиглэгдэж байгаа юм. Энэхүү зорилт ч авилгыг нөхцөлдүүлдэг аливаа хэм хэмжээ, шат дамжлага, хүнд суртал, чирэгдлийг бүрмөсөн арилгахад чиглэсэн нийтийн зорилготой яв цав нийцнэ гэж үзэж байгаа юм.

Үүний зэрэгцээ аливаа тодорхой харилцааг аль нэг төрийн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр бус боломжийн хирээр хуульчлах буюу ард түмний төлөөллийн бүрэлдэхүүнээр хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй юм гэж үзэж байгаа болно. Өөрөөр хэлбэл цаашид зохицуулалт шаардагдаж байгаа харилцааг хуульчлах замаар захиргааны актыг цөөрүүлэх бодлогыг баримталж байгаа юм.

Түүнчлэн Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн үзэл санаа болох хууль, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, хуулийг шинэчилсэн найруулгаар өргөн барихдаа хуулийг дагаж гарах Засгийн газрын тогтоол, хууль хэрэгжүүлэх хүрээнд боловсруулсан нийтлэг хэм хэмжээ тогтоосон яамд, агентлагийн удирдлагын шийдвэрийн төслийг багцаар нь дээд байгууллагад оруулж байх асуудал практикт хэрэгжихгүй байгаа байдлыг өөрчлөх шаардлага байсаар байна.

Амьдралд зөвхөн хууль нь түрүүлээд батлагдчихдаг, харин уг хуулийг хэрэгжүүлэх дүрэм, журам нь сар, улирал, жил дамнан батлагдахгүй, олон нийтэд хүрдэггүйгээс улбаалан хууль хэрэгжих боломж муутай болдог төдийгүй иргэд, байгууллага ч мухардаж, чирэгдэж, “аливааг аргалах” арга ухаан хайж эхэлдэг нь нууц бус юм.

Уг асуудлыг зохистой шийдвэрлэх нь авилгыг эцэслэх бас нэг нөхцлийг бүрдүүлэх болно гэж үзэж байгаа юм.

- **Сургалт, сурталчилгааны чиглэлээр**

Авилгын чиг хандлагыг танадах, тодорхойлох чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй үндэсний болоод гадаадын төрийн бус, түүнчлэн судалгаа-шинжилгээний байгууллагаас тодорхой хугацаанд хийж буй судалгааны дүнд тулгуурлан иргэдийн дунд гэгээрүүлэх буюу нийгэмд авилгыг үл тэвчих уур амьсгал бүрдүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг үр дүнтэй арга хэлбэрээр зохион байгуулахад анхаарлаа хандуулж байна.

Авилгатай тэмцэх тухай хууль батлагдсан даруйд уг асуудлыг хуулиар хариуцсан тусгайлсан байгууллага, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран дээрх ажлыг зохион байгуулж байна.

Энэхүү ажлыг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

Олон нийтийг гэгээрүүлэх ажлыг иргэдэд хамгийн ойр дөт байдаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түлхүү зохион байгуулах, түүнчлэн хялбаршуулсан гарын авлага, эвхмэл, нугалбар хуудас, өнгөт зурагт хуудас боловсруулан олон нийт танилцаж болохуйц газар, тухайлбал шүүх, прокурор, цагдаа, төрийн үйлчилгээний асуудал эрхэлсэн байгууллага, кинотеатр зэрэгт байрлуулах зэрэг эхний сэтгэгдлээр агуулга, ач холбогдлын хувьд өгөөжтэй, үр дүнтэй байж болох ажлыг санаачлан эхлүүлээд байна.

Хүн бүхэн заавал биелүүлж, мэдэж байх ёстой хүн ёсны жудгийг эрхэмлэх, үүний эсрэг цээрлэх ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх, ёс суртахууны үндсэн зарчмуудыг мэддэг болгох, өөртөө хандах ёс суртахууны үнэлэмжийг дээшлүүлэх, хүнээс их хүч хөдөлмөр, мэдлэг, ухаан зарж байж олж авдаг нэр хүндийг ямагт бүтнээр нь хадгалж, өргөж явахын утга учрыг

иргэдэд ялангуяа залуучуудад итгүүлэх, сурталчлахад соён гэгээрүүлэх ажил чиглэгдэх ёстой.

- **Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, Онлайн үйлчилгээнд шилжих, үйлчилгээг иргэдэд ойртуулах**

Авилгын асуудлаар хийгдсэн судалгаанд авилгад өртөмтгий, энэ чиглэлээр зонхилох байрыг тогтвортой эзэлж байгаа байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, төрийн үйлчилгээ, ялангуяа бүртгэл, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, албан тушаалтанд тавих шаардлагыг дээшлүүлэх, хяналтыг өндөржүүлэх, үйлчилгээг иргэдэд ойртуулах боломжит арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Иргэд өдөр тутам, цаг тутам, хором тутам хүртэж байх ёстой үйлчилгээ хөшүүн хойрго, олон шатлалтай, хүнд сурталтай байх боломжийг хязгаарласан арга хэмжээг авч байна.

Тухайлбал, төрийн үйлчилгээг хүртээх чиг үүрэгтэй байгууллагуудын хувьд Онлайн үйлчилгээг нэвтрүүлэх, бүх үйлчилгээг иргэдэд нэг цэгээс хүртээх, үйлчилгээтэй холбогдсон мэдээллийг олон хэлбэрээр түгээх, биечлэн зөвөлгөө өгөх, иргэдийн асуудал шийдвэрлэгдсэн тухайд эзэнд нь эргэж мэдээлэх зэрэг төрийн үйлчилгээний стандартыг хэвшүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг явуулж байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд өдөр тутам хүргэх чиг үүрэгтэй байгууллагуудын ажилтнуудад тусгайлсан сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөрт мэргэжлийн онолын хичээлийн зэрэгцээ албаны ёс зүй, харилцааны соёл, сэтгэл зүйн хичээлийг дадлагажуулах, практик-дадал олгох асуудалтай хамтатган оруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

- **Авилгатай тэмцэхэд захиргааны байгууллагын нэгдмэл байдлыг хангах, хамтын ажиллагаа**

Авилгатай холбоотойгоор иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтны нэр дээр ирж байгаа өргөдөл, гомдлыг анхааралтай авч үзэж, үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдал, доголдлыг засч залруулах, буруутай хүмүүст хариуцлага тооцоход анхаарч ажиллаж байна

Гэхдээ бидэнд энэ талаар эрчимтэй, шуурхай, үр дүнтэй ажиллах шаардлага байгааг ч дурдах нь зүйтэй.

Цагдаа, тагнуул, хил хамгаалах ерөнхий газрын Тагнуулын алба нь хуулиар өөрсдөд нь олгогдсон эрхийн хүрээнд иргэдээс ирсэн гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэх талаар төдийлөн хангалттай ажиллаж чадахгүй байна. Эдгээр байгууллагууд асуудлыг Авилгатай тэмцэх газартай хамтран шалгах, харилцан мэдээлэл солилцох зэргээр ажиллах нь тодорхой үр дүнд хүрэхэд нөлөөлнө гэж бодож байна.

Дээрх байгууллагууд буюу цагдаа, тагнуулын байгууллагууд авилгын гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг олон эх сурвалжаар давхар нотолж, баримтжуулсан байхыг чухалчлах хэрэгтэй.

Нотлогдоогүй мэдээ, мэдээллээр иргэдийн хууль ёсны эрх, эрх чөлөөг хөндөх, хэлмэгдүүлэх асуудал гаргахгүй байхад ч авилгатай тэмцэл явуулж буй байгууллага, тэдгээрийн ажилтнууд онцгой анхаарч ажиллах ёстой.

Нэр хаяггүй захидал, мэдээлэл, сонин хэвлэл дээр гарсан зохиогч нь тодорхойгүй, батлагдаж, нотлоглоогүй мэдээ материал, гүжирдлэг, гүтгэлэгт автаж, эсхүл “ийм ажилд томилогдсон юм чинь идэж, ууж л байгаа биз” гэсэн баримжаагүй хоосон хардлага сэрдлэгээр асуудалд хандаж, хэн нэгнийг хохироож болохгүй нь бүр ойлгомжтой.

Авилгалтай тэмцэх ажлын үр дүн нь хамтын хүчин чармайлтаас ихээхэн шалтгаална.

Энд би Засгийн газрын байгууллагуудаас гадна авилгатай тэмцэх асуудлаар хуулийн байгууллагын хамтын ажиллагааг хамтатган ярихыг хүсч байна.

Хамтын ажиллагааны хүрээнд авилгатай тэмцэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дор бүрнээ хийж байгаа ажлаа харилцан мэдээлэх, санал солилцох болон зөвлөлдөх, ажил хэргийн бусад уулзалтыг зохион байгуулах, хилийн чанад дахь ижил зорилготой байгууллага, түншлэгчдийн туршлагыг харилцан ярилцах, амьд, бодитой ажил хэрэг болгох гээд олон зүйлийг хийж болох байна гэдгийг тэмдэглэж байна.

Хамгийн чухал нь зорилго нэгт ажилтнууд цаг зав гарган цуглаж, ярилцсан, зөвлөлдсөн асуудлаараа зөвлөмж, санаачлага гаргаж, шийдвэрийг

хэрэгжүүлэх практик алхам хийх, даацтай арга хэмжээ авч ажиллахыг эрмэлзэх хэрэгтэй.

- **Төрийн албан хаагчийн ёс зүй**

Төрийн албыг ёс зүйтэй хашиж, хуулийг чанд сахин албан үүргээ журамтайгаар гүйцэтгэж байгаа олон мянган албан хаагчдын зэрэгцээ авилгад автдаг, түүнийг хүлээн зөвшөөрдөг хэсэг байдгийг илтгэлийн эхэнд дурдсан судалгааны дүн нэгэнт харуулсан билээ.

Төрийн албан хаагчид цалин бага, ахуй хангамж дорой байгаа нь “авилга авахаас яахав” гэсэн яриа цаад утгаараа авилгыг зөвтгөж, тэднийг сэтгэл зүйн хувьд бэлтгэж байгаа авилгачдын явуулага гэж үзвэл зохилтой.

Хэрэв төрийн албан хаагч цалин , ахуй хангамжиндаа сэтгэл дундуур байдаг бол түүнд өөр салбарт хүчээ сорих, амьдралаа дээшлүүлэх сонголт бүрэн чөлөөтэй байгаа шүү дээ.

Ийм байсаар байтал төрийн албанд хоргодох нь түүнд ямар нэг хоёр дахь сонирхол байж болзошгүйн тэмдэг.

Ийм бодол санаатай албан хаагчдын цалинг хичнээн нэмсэн ч, ажиллах нөхцөлийг яаж сайжруулсан ч авилга авах магадлал байнга байх тул ийм бодол санаатай хүмүүсээс төрийн албыг хамгаалах хэрэгтэй гэж бодож байна.

- **Хяналт, мониторингийн асуудал**

Авилгатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хууль, хөтөлбөр, Монгол Улс нэгдэн орсон конвенцийн хэрэгжилтийг үнэлэх, түүнд мониторинг хийх асуудлыг тодорхой хугацаанд хөндлөнгийн шинжээч, судлаач, иргэний нийгмийн төлөөллийн идэвхтэй оролцоотойгоор гүйцэтгэж байх нь бидний энэ чиглэлд явуулж буй бодлого, зохион байгуулж буй ажлын бодитой үр дүнг харуулах юм.

Энэхүү мониторинг, хяналт шинжилгээний үр дүн нь цаашид биднээс тогтмол зохион байгуулах ажил, арга хэмжээг боловсронгуй, илүү үр дүнтэй төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд тус дэм болно гэж үзэж байна.

- **Дүгнэлт**

Авилга нь эдийн засаг, нийгэм, соёл, оюуны амьдралын маш олон нөхцөл шалтгаантай байдаг учраас түүний эсрэг тэмцлийг бүх чиглэлээр өрнүүлж, иж бүрэн арга хэмжээ авч баймааж үр дүнд хүрэх нь ойлгомжтой.

Нөгөө талаас авилгатай хийх тэмцлийг зөвхөн төрийн байгууллага дангаараа бус иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэд олон нийтийн өргөн оролцоог хангаж, хүчийг нэгтгэж, бие биенийхээ дутууг нөхөж, ажиллаж байж амжилтанд хүрнэ.

Гэхдээ хамтын ажиллагаа чухал гээд тунхаглаад суулгүй хэн юу хийх, өөрөөр хэлбэл ажил үүргийн хуваарийг тодорхой тогтоож, хамтын ажиллагааны үр ашигтай, оновчтой механизмыг бий болгох шаардлагатай байна.

Авилгач нарт нэр төр, нинжин сэтгэл, шударга ёс гэж үгүй.

Авилгатай, авилгачидтай тэмцэх ажлыг улс төрөөс хараат бус байлгахын чухлыг миний илтгэлийн эхэнд дурдсан судалгааны дүн бэлхнээ харуулж байгааг энд зориуд тэмдэглэж байна.

Авилгыг илрүүлэх, цаашид газар авахуулахгүй байх, улмаар хүрээг нь хумих, уг сурвалж, нийгмийн шалтгааныг нь судалж арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр бидэнд цаашид хийх ажил маш их байна.

Энэ чиглэлээр бүх байгууллага, иргэдтэй бид хамтран ажиллахад бэлэн гэдгийг хэлэхэд таатай байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа

Үндэсний Бага Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэе.

